



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/42

Хэрлэн сум

Зураг, төсвийн ажил гэрээгээр
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Төрийн нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3, 3.4, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 3 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллага болох аймгийн Цагдаагийн газрын конторын барилга, Цэнхэрмандал сумын Шалган нэвтрүүлэх үйлчилгээний төвийн барилга, Чингис хотын камержуулалтын ажлын зураг, төсвийг боловсруулах аж ахуйн нэгж, байгууллагыг сонгож гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг аймгийн Цагдаагийн газар /О.Ганбат/-т зөвшөөрсүгэй.

2. Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Гэрээ байгуулан гүйцэтгүүлэх ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс /Л.Бат-Октябрь/-т үүрэг болгосугай.

4. Зураг төсвийн ажлыг гэрээ байгуулан гүйцэтгүүлэхтэй холбоотой хөрөнгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 294

02. Аймгийн Засаг даргын 2017 оны
дугаар сарын 03 өдрийн 4/02
дугаар захирамжийн хавсралт



ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗАРДЛЫН ЖАГСААЛТ, ТООЦОО

Д/д	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төрөл	Үнэ /төгрөгөөр/
1.	Аймгийн Цагдаагийн газрын шинэ конторын барилгын зураг, төсөв хийх зардал	37.7 сая
2.	Чингис хотын камержуулалтын ажлын зураг, төсөв хийх зардал	18.0 сая
3.	Цэнхэрмандал сумын Шалган нэвтрүүлэх үйлчилгээний төвийн барилгын зураг, төсвийг хийх зардал	2.3 сая
Нийт дүн		58.0 сая